

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТАВАНТОЛГОЙН ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨСЛИЙН НЭГЖИЙН  
ЗАХИРАЛ Г.ГАНЗУЛ ТАНАА

2020.03.13 № 06/782  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус төсвийн байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус нэгжийн захирал Г.Ганзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлд хөрөнгийн элэгдлийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалтыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн хөгжүүлэлтийг байнга хийж сайжруулж байх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 24-өөс 2020 оны 3-р сарын 3-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Б.Анармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь *"Монгол Улсын төв болон Өмнийн бүс нутагт эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох"* -д оршино.

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Тавантолгойн цахилгаан станц барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэрийн тооцоог хийх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 33 асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 6,357,749.6 мянган төгрөгөөс тооцон 127,155.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,627,450.6 мянган төгрөгөөс тооцон 92,549.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,017,584.1 мянган төгрөгөөр буюу 14.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, нийт өр төлбөрийн данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,718,587.6	3,732,254.4	(2,986,333.2)
Авлага	3,186.4	2,560.0	(626.4)
Урьдчилж гарсан зардал	14,628,344.9	14,628,344.9	0
Бараа материал	6,166.2	9,106.2	2,940.0
Үндсэн хөрөнгө	229,379.4	195,814.9	(33,564.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>21,585,664.5</b>	<b>18,568,080.4</b>	<b>(3,017,584.1)</b>
Өр төлбөр	39,911,137.6	41,279,169.0	1,368,031.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	(18,325,473.1)	(22,711,088.6)	(4,385,615.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>21,585,664.5</b>	<b>18,568,080.4</b>	<b>(3,017,584.1)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,986,333.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нэмж зээлийн ашиглалт гараагүй, өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд 626.4 мянган төгрөгийн авлага барагдсан нь шалтгаалжээ. Ньюс Аженси ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2016 онд үүссэн вэб сайтад мэдээ мэдээлэл байршуулах төлбөрт шилжүүлсэн авлага 2,560.00 мянган төгрөг барагдаагүй байна.

Энэ нь Ньюс Аженси ХХК-тай байгуулсан гэрээг шинэчлэн байгуулж үлдэгдэл ажил үйлчилгээг дараах онуудад авахаар тохиролцсон авлага байна.

Урьдчилж гарсан зардлын 14,628,344.9 мянган төгрөг нь 2013 оноос эхлэн тус төслийн нэгжийн бэлтгэл ажлыг хангахад зарцуулсан зардлыг Тавантолгойн цахилгаан станцын хөрөнгө оруулалтын гэрээний 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу хөрөнгө оруулагч тал 100 хувь төлөхөөр үүрэг хүлээсэн, цахилгаан станц баригдаж дууссаны дараа станцын өртөгт шингэх зардал байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2019 онд 38,781.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 35,481.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, өнгөрсөн оны үлдэгдлээс 2,940.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бичиг хэрэг болон сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь 13,303.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, төслийн нэгжийн захирлын 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/11 тоот тушаалаар 1,834.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, биет бус хөрөнгө акталж данснаас хасалт хийсэн, хуримтлагдсан элэгдэл 46,868.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ

Богино болон урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,368,031.4 мянган төгрөгөөр өссөн нь урд онуудад авсан төслийн зээл, зээлийн хүү төлөгдөөгүй ба гадаад валютын ханшийн зөрүүгээр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22,711,088.6 мянган төгрөг болж 4,385,615.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагаанаас үүссэн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, төслийн зээлийн хүү, хөрөнгийн урсгал зардал, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал, гадаад, дотоодын томилолтын зардал, тээврийн хэрэгслийн зардал зэрэг нь өмнөх оноос 99,677.6 мянган төгрөгөөр буюу 21,7 хувиар өссөнтэй холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 3,730,901.8 мянган төгрөгийг Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Нийт төсвөөс 3,440,101.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 290,800.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан үзэхэд дараах зардлууд хэмнэгдсэн байна. Үүнд: цалингийн зардал 20,246.2 мянган төгрөг хэмнэсэн нь төслийн нэгжийн орон тоо буурснаас, түрээсийн зардал 16,990.2 мянган төгрөг хэмнэсэн нь ажлын байрны талбайн хэмжээ буурснаас, бараа материалын зардал 3,949.5 мянган төгрөг хэмнэсэн нь бичиг хэргийн худалдан авалтаас, томилолт зочны зардал 51,538.0 мянган төгрөг хэмнэсэн нь гадаад томилолтоор зардал багассанаас, үйлчилгээний зардал 37,495.7 мянган төгрөг хэмнэсэн нь сургалтанд бага зардал зарцуулснаас, төслийн зээлийн хүүгийн зардал 146,056.3 мянган төгрөг хэмнэсэн нь Монгол банкны ханшийн зөрүүнээс шалтгаалсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд 33 эрсдэл тодорхойлж нийт 33 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 229,009.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 228,109.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 899.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6 “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ. Бүх зардал*” гэсэн заалттай нийцэхгүй иж бүрэн, оршин байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй дараах алдаануудыг санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

- Тавилга эд хогшлын элэгдлийн зардал 12,309.9 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад тусгаагүй.
- Мөнгөн гүйлгээний тайланд 215,799.4 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүг хөрөнгө оруулалтын орлогын дүнд тайлагнасан.

Аудитаар илэрсэн 2,734.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 80, 129 дугаар тогтоолыг үндэслэн Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн 450 МВт чадалтай цахилгаан станц барьж байгуулахаар Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгж байгуулагдсан байна. Тавантолгойн цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах зорилгоор Монгол Улсын засгийн газар, Оюу толгой ХХК-ийн хооронд Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын гэрээг 2018 оны 12 дугаар сарын 31-



ний өдөр байгуулсан байна. Тус гэрээнд станцын хүчин чадлыг бууруулан 300 МВт болгон өөрчилж талуудын хийж гүйцэтгэх ажлыг цаг хугацааны дарааллаар тодорхойлсон байна. Гэрээнд заасан санхүүжилтийн зарчмуудыг талууд тохиролцох хэлэлцээрийг дуусгаж, нэгдсэн нэг зарчимд байгаа тул төслийн хөрөнгө оруулалт болон бусад ажлууд хийгдэх хугацаа хойшилж, хүлээлтийн байдалд байна гэсэн тайлбарыг тус нэгжээс өгсөн болно.

Төслийн нэгжийн үйл ажиллагаа хумигдаж, хязгаарлагдмал байгаатай холбоотой Хөгжлийн банкнаас олгосон зээл 2019 оны жилийн эцсийн байдлаар 14,816.3 мянган ам доллар буюу 40,500,518.5 мянган төгрөг, зээлийн хүүний төлбөр 284.9 мянган ам доллар буюу 778,650.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба үйл ажиллагааны үр дүнгээр 22,711,088.6 мянган төгрөгийн хуримтлагдсан алдагдал хүлээгээд байна.

Төрийн нэрийн өмнөөс гаргасан эдгээр зардал хэзээ ямар эх үүсвэрээс нөхөгдөх, хэрхэн шийдвэрлэгдэх асуудал тодорхойгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тухайн жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд нь 42, хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Залруулаагүй 899.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 *Балансын данстай холбоотой асуудал*

**3.1.1 Илрүүлэлт:** Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэх ёстой 899.9 мянган төгрөгийн хөрөнгийг аж ахуйн материалд бүртгэсэн. Энэ нь үнэн зөв, толилуулаг ба тодруулга гэсэн батламж мэдэгдэл, мөн Сангийн сайдын 388-р тушаалын 4.29-д заасан УСНББОУС 17 “*Үндсэн хөрөнгө*” дагаж мөрдөнө гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**3.1.2 Эрсдэл:** Санхүүгийн тайлан буруу тайлагнах, бараа материалын зохистой үлдэгдэл алдагдах, дотоод хяналт сул байх

#### 3.1.3 *Өгсөн зөвлөмж:*

Хөрөнгийн ангиллыг заавар журмын дагуу зөв бүртгэж байх, дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

#### 3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Асуудлыг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэхээр болсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,356,285,198.84</b>	<b>18,372,265,550.38</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>6,718,587,644.13</b>	<b>3,732,254,379.98</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>222,800.00</b>	<b>118,673.00</b>
31110	Төгрөг	222,800.00	118,673.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>5,910,941,208.14</b>	<b>3,732,135,706.98</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>14,360,771.34</b>	<b>28,897,354.84</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	14,360,771.34	28,897,354.84
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	<b>5,896,580,436.80</b>	<b>3,703,238,352.14</b>
31223	Арилжааны банк дахь харилцах	5,896,580,436.80	3,703,238,352.14
31400+315	Хадгаламж	807,423,635.99	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,186,352.26</b>	<b>2,560,000.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>3,186,352.26</b>	<b>2,560,000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	3,186,352.26	2,560,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>14,628,344,993.41</b>	<b>14,628,344,993.41</b>
34600	Урьдчилж гарсан зардал	14,628,344,993.41	14,628,344,993.41
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6,166,209.04</b>	<b>9,106,176.99</b>
354	Хангамжийн материал	<b>6,166,209.04</b>	<b>9,106,176.99</b>
35410	Бичиг хэргийн материал	1,022,710.00	1,716,570.00
35420	Аж ахуйн материал	1,318,000.00	1,573,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,340,000.00	5,316,300.00
35440	Түлш, шатах тослох материал	485,499.04	499,406.99
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>229,379,286.52</b>	<b>195,814,861.47</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>229,379,286.52</b>	<b>195,814,861.47</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>229,198,153.02</b>	<b>195,633,727.97</b>
39203	Авто тээврийн хэрэгсэл	395,400,000.00	395,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(226,466,666.88)	(261,025,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	77,044,820.00	76,017,020.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,044,820.00)	(76,017,020.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	118,249,043.00	131,552,798.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,984,223.10)	(70,294,070.03)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>181,133.50</b>	<b>181,133.50</b>
39301	Програм хангамж	4,002,117.00	3,195,000.00
39302	Хасагдуулга	(3,820,983.50)	(3,013,866.50)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>21,585,664,485.36</b>	<b>18,568,080,411.85</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>39,911,137,617.86</b>	<b>41,279,169,013.36</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>752,971,524.94</b>	<b>778,650,579.84</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>752,971,524.94</b>	<b>778,650,579.84</b>
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	128,574.20	-
41350	Зээлийн хүүгийн өглөг	752,842,950.74	778,650,579.84
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>39,158,166,092.92</b>	<b>40,500,518,433.52</b>
42000	Урт хугацаат зээл	<b>39,158,166,092.92</b>	<b>40,500,518,433.52</b>
<b>422</b>	<b>Гадаад валют</b>	<b>39,158,166,092.92</b>	<b>40,500,518,433.52</b>
42224	Төслийн зээл	39,158,166,092.92	40,500,518,433.52
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>(18,325,473,132.50)</b>	<b>(22,711,088,601.51)</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	<b>(18,325,473,132.50)</b>	<b>(22,711,088,601.51)</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	<b>(18,325,473,132.50)</b>	<b>(22,711,088,601.51)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(12,697,833,079.39)	(18,325,473,132.50)
51220	Тайлант үеийн үр дүн	(5,627,640,053.11)	(4,385,615,469.01)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>21,585,664,485.36</b>	<b>18,568,080,411.85</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>21,023,864.16</b>	<b>26,035,760.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,023,864.16</b>	<b>26,035,760.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>16,665,291.91</b>	<b>15,098,006.06</b>
120002	Хүүгийн орлого	16,665,291.91	15,098,006.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>4,358,572.25</b>	<b>10,937,754.07</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,358,572.25	10,937,754.07
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,034,182,514.11</b>	<b>3,234,059,521.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,034,182,514.11</b>	<b>3,234,059,521.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,111,047,668.20</b>	<b>740,150,024.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>383,428,803.93</b>	<b>429,186,931.71</b>
210101	Үндсэн цалин	373,111,138.80	424,245,732.04
210105	Гэрээт ажлын хөлс	10,317,665.13	4,941,199.67
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,256,273.90</b>	<b>52,605,094.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,442,179.44	36,590,952.96
210202	Тэтгэмжийн даатгал	3,805,272.43	4,304,817.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,745,138.85	3,415,694.39
210204	Ажилгүйдлийн даатгал	744,262.12	753,966.29
210205	Эрүүл мэндийн даатгал	7,519,421.06	7,539,662.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,407,661.92</b>	<b>65,340,113.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,760,092.00	1,515,707.00
210302	Түлш, халаалт	2,717,251.45	2,956,805.33
210303	Цэвэр, бохир ус	617,350.73	579,645.50
210304	Байрны түрээс	81,312,967.74	60,287,955.84
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,012,037.72</b>	<b>22,307,837.80</b>
210401	Бичиг хэрэг	4,363,450.00	3,434,202.00
210402	Тээвэр, шатахуун	8,144,805.97	10,084,514.05
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,824,501.75	7,304,515.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,573,000.00	30,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,106,280.00	1,454,606.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,400.00</b>	<b>39,000.00</b>
210604	Урсгал засвар	43,400.00	39,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,293,647.20</b>	<b>37,823,361.36</b>
210701	Гадаад албан томилолт	7,956,351.20	20,705,365.36
210702	Дотоод албан томилолт	3,664,300.00	13,746,635.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,672,996.00	3,371,361.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>55,280,762.89</b>	<b>38,731,775.95</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,222,850.00	15,134,390.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,987,848.00	7,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,814,760.00	5,103,467.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,913.00	615,913.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,216,480.00	8,386,169.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,728,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын	1,788,911.89	1,591,836.95

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	үйлчилгээний хураамж		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>505,325,080.64</b>	<b>94,115,909.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	413,514,383.25	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	47,247,729.05
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,810,697.39	46,868,180.05
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>1,923,134,845.91</b>	<b>2,493,909,497.36</b>
<b>2111</b>	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>1,923,134,845.91</b>	<b>2,493,909,497.36</b>
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,923,134,845.91	2,493,909,497.36
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(3,013,158,649.95)</b>	<b>(3,208,023,761.32)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>709,085,681.91</b>	<b>215,799,356.42</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	709,085,681.91	215,799,356.42
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,323,567,085.07</b>	<b>1,393,391,064.11</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	3,323,567,085.07	1,393,391,064.11
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(2,614,481,403.16)</b>	<b>(1,177,591,707.69)</b>
<b>VI</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(5,627,640,053.11)</b>	<b>(4,385,615,469.01)</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>20,999,035.63</b>	<b>26,035,760.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,999,035.18</b>	<b>26,035,760.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>16,665,291.91</b>	<b>15,098,006.06</b>
120002	Хүүгийн орлого	16,665,291.91	15,098,006.06
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,333,743.27</b>	<b>10,937,754.07</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого	4,333,743.27	10,937,754.07
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,883,560,188.09</b>	<b>3,163,825,902.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,883,560,188.09</b>	<b>3,163,825,902.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,021,893,734.90</b>	<b>695,724,033.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>383,202,243.92</b>	<b>429,315,505.79</b>
210101	Үндсэн цалин	369,589,762.79	424,374,305.79
210104	Урамшуулал	3,900,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	9,712,481.13	4,941,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,354,259.71</b>	<b>52,605,094.62</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,442,179.44	36,563,752.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,805,272.40	4,301,617.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,843,124.62	3,415,694.43
210204	Ажилгүйдлийн даатгал	744,262.11	784,366.27
210205	Эрүүл мэндийн даатгал	7,519,421.14	7,539,663.01
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,784,158.18</b>	<b>64,873,761.41</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,633,412.00	1,515,707.00
210302	Түлш, халаалт	2,627,395.45	2,956,805.33
210303	Цэвэр, бохир ус	617,350.73	579,645.50
210304	Байрны түрээс	81,906,000.00	59,821,603.58
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,418,885.75</b>	<b>25,718,216.75</b>
210401	Бичиг хэрэг	2,514,850.00	4,393,802.00
210402	Тээвэр, шатахуун	8,215,208.00	9,351,172.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,824,501.75	7,144,515.75
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,864,326.00	4,828,727.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>153,400.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	153,400.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,722,941.20</b>	<b>34,452,000.36</b>
210701	Гадаад албан томилолт	7,956,351.20	20,705,365.36
210702	Дотоод албан томилолт	3,664,300.00	13,746,635.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,102,290.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,743,462.89</b>	<b>41,511,725.95</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,121,500.00	4,906,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,987,848.00	7,900,000.00

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	7,814,760.00	5,103,467.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,913.00	615,913.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	11,780,530.00	21,393,959.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,728,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,788,911.89	1,591,836.95
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>414,514,383.25</b>	<b>47,247,729.05</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	413,514,383.25	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	47,247,729.05
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>1,861,666,453.19</b>	<b>2,468,101,868.26</b>
<b>2111</b>	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>1,861,666,453.19</b>	<b>2,468,101,868.26</b>
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,861,666,453.19	2,468,101,868.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,862,561,152.46</u></b>	<b><u>(3,137,790,142.06)</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,339,100.00</b>	<b>13,303,755.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,339,100.00</b>	<b>13,303,755.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	7,339,100.00	13,303,755.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(7,339,100.00)</u></b>	<b><u>(13,303,755.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b><u>709,085,681.91</u></b>	<b><u>215,799,356.42</u></b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>709,085,681.91</b>	<b>215,799,356.42</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүү	709,085,681.91	215,799,356.42
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>24</b>	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>25</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>126,368,281.78</b>	<b>51,038,723.51</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	126,368,281.78	51,038,723.51
<b>8</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>582,717,400.13</u></b>	<b><u>164,760,632.91</u></b>
<b>9</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-2,287,182,852.33</b>	<b>(2,986,333,264.15)</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9,005,770,496.46</b>	<b>6,718,587,644.13</b>
<b>11</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,718,587,644.13</b>	<b>3,732,254,379.98</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>(12,697,833,079.39)</b>	<b>(12,697,833,079.39)</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>(12,697,833,079.39)</b>	<b>(12,697,833,079.39)</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн	-	-	(5,627,640,053.11)	(5,627,640,053.11)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>(18,325,473,132.50)</b>	<b>(18,325,473,132.50)</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>(18,325,473,132.50)</b>	<b>(18,325,473,132.50)</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн	-	-	(4,385,615,469.01)	(4,385,615,469.01)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>(22,711,088,601.51)</b>	<b>(22,711,088,601.51)</b>



#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,730,901,844.00</b>	<b>3,228,168,380.70</b>	<b>502,733,463.30</b>	<b>86.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,440,101,844.00</b>	<b>3,163,825,902.19</b>	<b>276,275,941.81</b>	<b>91.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>825,943,618.00</b>	<b>695,724,033.93</b>	<b>130,219,584.07</b>	<b>84.2</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>446,480,000.00</b>	<b>429,315,505.79</b>	<b>17,164,494.21</b>	<b>96.1</b>
Үндсэн цалин	428,880,000.00	424,374,305.79	4,505,694.21	98.9
Гэрээт ажлын хөлс	17,600,000.00	4,941,200.00	12,658,800.00	28.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>55,686,800.00</b>	<b>52,605,094.62</b>	<b>3,081,705.38</b>	<b>94.4</b>
Тэтгэврийн даатгал	37,774,800.00	36,563,752.92	1,211,047.08	96.7
Тэтгэмжийн даатгал	4,464,400.00	4,301,617.99	162,782.01	96.3
ҮОМШӨ-ний даатгал	3,659,320.00	3,415,694.43	243,625.57	93.3
Ажилгүйдлийн даатгал	858,380.00	784,366.27	74,013.73	91.3
Эрүүл мэндийн даатгал	8,929,900.00	7,539,663.01	1,390,236.99	84.4
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>81,864,000.00</b>	<b>64,873,761.41</b>	<b>16,990,238.59</b>	<b>79.2</b>
Гэрэл, цахилгаан	2,760,000.00	1,515,707.00	1,244,293.00	54.9
Түлш, халаалт	4,540,000.00	2,956,805.33	1,583,194.67	65.1
Цэвэр, бохир ус	644,000.00	579,645.50	64,354.50	90.0
Байрны түрээс	73,920,000.00	59,821,603.58	14,098,396.42	80.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,667,718.00</b>	<b>25,718,216.75</b>	<b>3,949,501.25</b>	<b>86.6</b>
Бичиг хэрэг	4,395,740.00	4,393,802.00	1,938.00	99.9
Тээвэр, шатахуун	12,683,104.00	9,351,172.00	3,331,932.00	73.7
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	8,448,874.00	7,144,515.75	1,304,358.25	84.5
Аж ахуйн материал худалдан авах зардал	4,140,000.00	4,828,727.00	-688,727.00	116.6
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>85,990,000.00</b>	<b>34,452,000.36</b>	<b>51,537,999.64</b>	<b>40.0</b>
Гадаад албан томилолт	60,990,000.00	20,705,365.36	40,284,634.64	33.9
Дотоод албан томилолт	25,000,000.00	13,746,635.00	11,253,365.00	54.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>56,755,100.00</b>	<b>41,511,725.95</b>	<b>15,243,374.05</b>	<b>73.1</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,980,000.00	4,906,550.00	73,450.00	98.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	7,900,000.00	4,100,000.00	65.8
Даатгалын үйлчилгээ	9,428,000.00	5,103,467.00	4,324,533.00	54.1
Тээврийн хэрэгслийн татвар	675,100.00	615,913.00	59,187.00	91.2
Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,000,000.00	21,393,959.00	6,606,041.00	76.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,672,000.00	1,591,836.95	80,163.05	95.2
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>69,500,000.00</b>	<b>47,247,729.05</b>	<b>22,252,270.95</b>	<b>67.9</b>

Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,500,000.00	47,247,729.05	22,252,270.95	67.9
<b>ХҮҮ</b>	<b>2,614,158,226.00</b>	<b>2,468,101,868.26</b>	<b>146,056,357.74</b>	94.4
<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>2,614,158,226.00</b>	<b>2,468,101,868.26</b>	<b>146,056,357.74</b>	94.4
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	2,614,158,226.00	2,468,101,868.26	146,056,357.74	94.4
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	-	-
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	-
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	-	-
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>290,800,000.00</b>	<b>64,342,478.51</b>	<b>226,457,521.49</b>	22.1
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>290,800,000.00</b>	<b>64,342,478.51</b>	<b>226,457,521.49</b>	22.1
Бусад хөрөнгө	290,800,000.00	13,303,755.00	277,496,245.00	4.6
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	51,038,723.51	(51,038,723.51)	-
<b>Гадаад эх үүсвэрээр</b>	-	-	-	-
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-	-	-
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>230,897,362.48</b>	<b>(230,897,362.48)</b>	-
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	<b>15,098,006.06</b>	<b>(15,098,006.06)</b>	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	15,098,006.06	(15,098,006.06)	-
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>215,799,356.42</b>	<b>(215,799,356.42)</b>	-
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	215,799,356.42	(215,799,356.42)	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>6,718,587,644.13</b>	<b>-6,718,587,644.13</b>	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>3,732,254,379.98</b>	<b>-3,732,254,379.98</b>	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	-
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>25</b>	<b>21</b>	<b>4</b>	84.0
Удирдах ажилтан	5	4	1	80.0
Гүйцэтгэх ажилтан	18	15	3	83.3
Үйлчлэх ажилтан	2	02	0	100.0

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:

2020-03-06

Аудитын нэр:

*Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код:

САГ-2020/94/СТА-ТХН

Шалгагдсан байгууллагын нэр:

*Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгж*

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1		2	3	4	5
1	Тоног төхөөрөмжийн дансанд бүртгэх агааржуулагчийн үнэ 899.9 мянган төгрөгийн хөрөнгийг аж ахуйн материалд ангилал сольж бүртгэсэн.	899.9	Зөвлөмж өгөх	Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн захирал, нягтлан бодогч	Г.Ганзул, Б.Туул
2	Мөнгөн гүйлгээний тайланд гадаад валютын ханшийн зөрүү 215,799.4 мянган төгрөгийн гүйлгээг хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний орлогын дүнд оруулж буруу тайлагнасан.	215,799.4	Залруулсан	Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн захирал, нягтлан бодогч	Г.Ганзул, Б.Туул
3	Тавилга эд хогшлын элэгдлийн зардал 12,309.9 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад тусгаагүй.	12,309.9	Залруулсан	Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгжийн захирал, нягтлан бодогч	Г.Ганзул, Б.Туул
<b>Дүн</b>		<b>229,009.2</b>			

